

## УЛС ТӨР, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

**ХЯТАДЫН ЦАГААЧ ИРГЭДИЙН АСУУДАЛ ЮУ  
ХАРУУЛЖ БАЙНА****М. Зэнээ**

Хятадын цагаач иргэдийн асуудал дэлхийн олон орны анхаарлыг татаж байна. Ялангуяа Зүүн Өмнөд Азийн улс орнуудын хувьд энэ нь ихээхэн бэрхшээлтэй асуудал байсаар ирэв. Хятад улс бүр XIII зууны үеэс эхлэн<sup>1</sup> иргэдээ нүүдлийн байдлаар цагаачлуулж эхэлжээ. Гадаадын хэвлэлийн мэдээнээс үзэхэд одоо дэлхийд 25 сая орчим хятад цагаач иргэд байгаа бөгөөд тэдний ихэнх нь Зүүн өмнөд Азийн орнуудад амьдардаг ажээ. Азид байгаа цагаач иргэд эдийн засгийн төдийгүй, улс төрийн талаар ч нөлөөтэй хүч болж байна. Тухайлбал Сингапурын хүн амын 80 хувь, Малайзын хүн амын 40 хувь нь хятад үндэстэн байна. Хамгийн багаар бодоход гадаадад суугаа цагаач иргэдийн 10 хувь нь томоохон хөрөнгөтөн байна.<sup>2</sup> Гадаадад суугаа хятад цагаачдын асуудалд хятадын маоистууд ихээхэн анхаарал хандуулж, тэднийг ашиглах замаар их гүрний үндсэрхэг дээрэнгүй бодлогоо хэрэгжүүлэх, бусад улс орны дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцох оролдлогыг гаргасаар ирсэн, гаргасаар ч байна. БНХАУ байгуулагдахаас өмнө тус орны төрийн дээд байгууллагад цагаач иргэдийн төлөөлөгчдийг сонгодог байсныг маоистууд шууд үргэлжлүүлсэн билээ. «Би хятад хүн. Би Сингапурт (Парист, Жакартад, Сан—Францискод г. м.) сууж байна. Би Хятад улсад хайртай» гэсэн өгүүлбэрээр дэлхийгээр тарсан хятад гаралтай хүмүүсийн дотор байгуулсан сургуулиуд хичээлээ эхэлдэг байсныг бодоход хятадын үндэсний дээрэнгүй үзэлтэй эрх баригчид үндсэрхэг үзлийг аль хэр дэвэргэсээр ирсэн болох нь тодорхой байна. Тэд «хятад хүний толгой нар шингэхийг үзэхгүй. Тиймээс бүх дэлхийн бөмбөрцөг бол Хятадынх юм» гэсэн үзлийг дэвэргэж иржээ.

1980-аад оны эхний үеийн мэдээгээр бол Тайландад 5 сая илүү, Малайзид 4 сая илүү, Индонезид 3 сая илүү, Сингапурт 2 сая илүү хятад байв. Зөвхөн АНУ-д 600 мянган хятад хүмүүс засаг захиргаа, аж үйлдвэр, шинжлэх ухааны янз бүрийн салбарт ажиллаж байдаг ажээ. Америкийн тоо бүртгэлийн мэдээнээс үзвэл АНУ-ын дээд сургуульд 7 мянган хятад гаралтай хүмүүс багшилж, янз бүрийн албан газар 12 мянган цагаач иргэд байгаагийн ихэнх нь Батлан хамгаалах яам, тагнуулын албанд байдаг<sup>4</sup> гэжээ. Үүнээс үзвэл хятадын цагаач иргэдийг улс төрийн бодлогодоо ашиглах оролдлого Бээжингийнхний анхаарлын төвд ямагт байдаг байсан нь тодорхой хэрэг. 1945 онд хуралдсан ХКН-ын VII их хурал дээр Мао Зэдун «хилийн гадна байгаа хятадын

<sup>1</sup>Б. Колосков. Внешняя политика Китая (1966—1976) М., 1977, 101-р тал.

<sup>2</sup>«Жэньминь жибао» 1978 оны 1-р сарын 4.

<sup>3</sup>В. Ванин. Пекин и китайская «эмиграция» М., 1980.

<sup>4</sup>«Литературная газета» 1978. V. 10. №19.

цагаач иргэдийн ашиг сонирхлыг хамгаалах» зорилт дэвшүүлж байсан юм. 1954, 1975 онуудад баталсан үндсэн хуульд цагаач иргэдийн талаар тусгай заалт оруулж байсан ба 1978, 1982 онд баталсан үндсэн хуулиудад «харьяат нар ба харьяат нарын гэр бүлийнхний хууль ёсны эрх ашгийг улсаас хамгаална»<sup>5</sup> гэсэн заалтыг давтан оруулжээ. Гэвч энэ заалт хилийн чанадад арай ядан амь зууж яваа жирийн хятад хүмүүсийн эрх ашгийг хамгаалахад чиглэгдээгүй болох нь олон зүйлээс ажиглагдсан юм. Үндсэн хуулийн дээрх заалт бол хятад цагаач иргэдийг ашиглан оршин суудаг улс орнуудын дотоод хэрэгт нь Бээжин дур зоргоор оролцох хууль ёсны эрхтэй байх гэсэн оролдлого болох нь Хятадын гадаад бодлогын олон жилийн практик ажиллагаанаас тодорхой харагдах болсон зүйл билээ. 1977 онд хуралдсан ХКН-ын XI их хурлын үеэр «цагаач иргэдтэй харьцах бодлого бол манай гадаад бодлогын чухал хэсэг» гэж хятадын албаны хүмүүс мэдэгдэж байсан билээ. Түүнээс гадна хятадын эрх баригчид гадаадад суугаа чинээлэг цагаач иргэдээрээ дамжуулан валют олох ажлыг нэгэн зэрэг хийж байна. Тухайлбал хилийн чанадад суугаа хятадууд жил бүр Хятад руу 1 миллиард гаруй доллар явуулж байна<sup>6</sup> гэж америкийн «Тайм» сэтгүүлд тэмдэглэжээ.

1983 оны 6-р сарыг 4-нд Бээжинд ажлаа эхэлсэн Бүх Хятадын Ардын Улс Төрийн Зөвлөлдөх Зөвлөлийн (БХАУТЗЗ) 6 дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулган дээр БХАУТЗЗ-ийн Байнгын хорооны дарга Дэн Инчао тавьсан илтгэлдээ «хятад цагаачдын тоо урьдах сонгуулиудаас их болсон»<sup>7</sup> гэж онцлон тэмдэглэсэн нь цагаач иргэдийн асуудалд ихээхэн анхаарал хандуулсаар байгаагийн баримт мөн.

БНМАУ бол БНХАУ-тай 5000 шахам км газраар хил залгадаг юм. Одоо үед БНМАУ-д амьдарч буй хятад иргэдийн тоо нэг их олон биш ч гэсэн тэдний доторх цөөн тооны хэсэгт манай улсын улс төр эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэх боломжийг хятадын тал олгосоор байна. Иймээс хятад цагаачдын асуудал нь манай улсад бусад орнуудын нэг адил нарийн төвөгтэй, ээдрээтэй асуудал байсаар байна. Ер нь Монгол нутагт хятад иргэд цагаачлан ирсэн нь нэлээд урт хугацааны түүхтэй билээ.

Ялангуяа манж гүрний ноёрхлын сүүлчийн жилүүдэд үй олон хятад иргэд Монголын өмнөт нутгаар нүүдлэн ирж суурьшсан юм.

Манж гүрний эхэн үед манжийн хаад Монгол газар хятад иргэдийг суурьшуулан тариа тариулах, газар хагалуулах явдлыг хориглосон цааз тогтоож байсан нь Монголд хятадын цагаач иргэд олширох явдлыг бага боловч саатуулж байсан тал бий. Ийм хориотой цагт хятад иргэд барилга байгууламж барих, ялангуяа сүм хийд барих нэрээр Монголоос буцахгүй суурьших явдал байжээ. Тэр үед Хятад орны хүн ам хэт олширч, ган гачиг тохиолдож байснаас болж өлсгөлөнд учирсан хятад тариачид бослого хөдөлгөөн байн байн гаргах болжээ. Үүнийг зогсоохын тулд Манжийн хаан Өвөр Монголын бэлчээр нутгийг хятад тариачидад зээлээр олгох болсон нь Монгол газар хятад иргэд олширох нөхцөл бүрдүүлжээ. Тэр үеийг «хятад хүмүүс... монгол газрын зүг усны урсгал мэт шурган орж иржээ»<sup>8</sup> гэж судлаачид тэмдэглэсэн байдаг. Ийнхүү цагаан хэрмээс гадагш хятад иргэдийг гаргахгүй гэсэн бодлого биелэхгүй болж тэд Монгол газар ирж суурьших

<sup>5</sup> «Хунци» сэтгүүл. 1978, №3, 65-р тал, БНХАУ-ын шинэ үндсэн хууль. Бээжин. 1982. 32-р тал.

<sup>6</sup> «Тайм» сэтгүүл. 1977. 12. 12., 25-р тал,

<sup>7</sup> «Жэньминь жибао» 1983. 6. 5.

<sup>8</sup> «Монгол түүх, хэл бичиг» сэтгүүл. Хөх хот. 1958, №1.

болсноор Монголын өмнөт хэсэг буюу Өвөр Монгол нь өмнөд хэсгээсээ эхлэн нүүдлийн байдлаа алдаж малын бэлчээр нь хомсдож хятадын тариалангийн суурьшмал амьдрал ихээхэн зонхилж аажимдаа хятадын нөлөөнд бүрмөсөн автаж эхэлжээ. Гэлээ ч гэсэн манж гүрний үед хятад иргэд монгол газар төдийлөн дур зоргоор суурьшин амьдрах бололцоо олгогдоогүй хэвээр байв. Манжийн төр хятад худалдаачдыг нэг жилээс хэтрэхгүй хугацаагаар Монголд худалдаа хийхийг зөвшөөрч «уул хугацаанаас хэтэрч худалдаалсан буюу худалдаа хийхийг зөвшөөрсөн тэмдэгт бичиггүй зоргоор худалдаа хийсэн этгээдийг... уг нутагт буцааж хөөх, худалдах зүйлийн хагасыг албанд хураан авах зэргээр яллан шийтгэж байжээ»<sup>9</sup>. Ийм байдал XIX зууны эцэс болтол хэвээр үргэлжилсэн юм. XX зууны эхэн үеэс Манжийн төр нь хүчин аяндаа суларч, төрийнх нь бодлогод Хятадын нөлөө давамгайлж ирэх үед Манж—Чин гүрний засгийн газраас Монголын талаар «шинэ засгийн бодлого» гэгчийг баримтлах болов. Энэ үед хятад иргэд Монгол нутагт нүүдэллэн ирэхийг хориглосон Манжийн хууль дүрэм хүчингүй болж, олон хятад иргэд нүүдэллэн ирж тариа ногоо тарих, худалдаа хийх, мөнгө хүүлэх гар үйлдвэрлэл эрхлэх зэргээр суурьших болов. Тэд Монголын ард түмнийг дарлан мөлжих олон арга хэрэглэж монголчуудын ширүүн эсэргүүцэлгэй тулгарч байсны дотор хамгийн гол зөрчил нь бэлчээр нутгийн төлөө тэмцэл байсан юм. Монголын ард түмнээс харийн дарангуйллын эсрэг явуулсан тэмцэл цаашдаа Манжийн төрийн эрх, хятадын худалдаа, эдийн засгийн ноёрхлыг эсэргүүцсэн нийт монголын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн болж хувирсан билээ. 1912 онд Дундат иргэн улс байгуулагдсаны дараа хятадын эрх баригчид Монголд хятад иргэдийг олшруулахыг аль болохоор эрмэлзэж байв. 1911—1919 оны үед Ар Монголд байсан хятадуудын тоо 100 мянгад хүрч байсан удаатай. Тэдний дотор мөнгө хүүлэгчид, худалдаачид, цэргийн хүмүүс хамгийн олон байв. Тэд монголын ард түмнийг улс төрийн хувьд залгихыг санаархахын зэрэгцээ эдийн засгийн хувьд туйлын хүнд байдалд оруулж, ард түмний аж амьдралыг улам доройтуулж, малын бэлчээрийг хагалан тариалж, ашиг хонжоо эрэх, байгалийн баялагийг хулгайн аргаар тонон дээрэмдэх, тэрчлэн монголчуудтай гэр бүл болох замаар монгол газар үүрд суух арга замыг сүвэгчилж, хятадууд монголчуудын амьдралын хүрээнд улам улам нэвтрэн орж, эрх дархаа бататгах, яваандаа эзэн эрх олж авах гэсэн далд санаа агуулж байжээ. Энэ бүх арга залигч монголчууд сайтар ойлгож тэдний эсрэг олон янзын тэмцлийг газар сайгүй өрнүүлж байв.

1921 онд Монголд Ардын хувьсгал ялсны дараа БНМАУ-д хятад хүний тоо улам улам цөөрсөөр ирсэн юм. Гэвч Ардын хувьсгал ялсны дараа БНМАУ-ын засгийн газар бүх гадаадын харьяат, түүний дотор хятадын харьяат нарын эрх чөлөөтэй амьдрах боломжийг бүх талаар хангаж байсан юм. Иймээс манай улсад оршин сууж байсан хятад иргэд ардын хувьсгалын жилүүдэд хувийн худалдааны янз бүрийн салбар эрхлэн худалдааны мухлаг, гуанз, жижиг гар үйлдвэр, үсчин, халуун усны үйлчилгээг эрхлэн амьдарч байв. Харин тэдний мөлжлөгийг хязгаарладаг байв.

1949 онд Хятадад хувьсгал ялж БНМАУ, БНХАУ хоёрын хооронд албан ёсоор дипломат харилцаа тогтсон нь хоёр улсын харилцаа цаашид хөгжих аятай нөхцлийг бүрдүүлсэн юм. 1950-иад оны эхэн үед Монгол дахь цагаач иргэд ихэвчлэн ажил хөдөлмөр эрхлэж, манай

<sup>9</sup>Ш. Нацагдорж, Халхын түүх, УБ., 1963, 97-р тал.

улсын хууль дүрмийг биелүүлдэг байв. Харин 1960-аад оноос Хятадын удирдагчдын маоист бодлого хоёр улсын харилцаанд илэрхий хүндрэл учруулж эхэлмэгц Монгол дахь хятад цагаачдын үйл ажиллагаа түүнийг дагалдан өөрчлөгдсөн юм.

1955 онд хоёр улсын хооронд байгуулсан хэлэлцээрийн үндсэн дээр мөн онд БНХАУ-аас 8 мянга гаруй хятад ажилчдыг 3 жилийн хуцаагаар БНМАУ-д ирүүлж хот хөдөөгийн барилга байгууламж дээр ажиллуулсан билээ. Эдгээр ажилчдын нэлээд хэсэг нь гэр бүлгүй залуу хүмүүс байлаа. Мөн 1958 онд 2 мянган ажилчин нэмж ирүүлсэн ба 1955 онд ирсэн бүх хятад ажилчдын 76 хувь нь дахин 3 жил ажиллах хүсэлтээ илэрхийлж байсан нь манай улсад ажиллах нөхцөл амьдрах бололцоо сайн байсны гэрч юм. Монголд ирсэн хятад ажилчид эхний жилүүдэд идэвхтэй сайн ажиллаж манай улсын засгийн газрын дээд шагналаар олон зуун хүн шагнуулж байв. Тэрчлэн манайд ажиллаж байсан хятад ажилчдын гэр бүлийн 17 мянга гаруй хүмүүсийн бүх зардлыг манай улс дааж авчирсан бөгөөд энэ тоо нь жинхэнэ ажиллахаар ирсэн хятад ажилчдын тоотой бараг тэнцэж байв.

1960-аад оноос хятад ажилчдын ажлын идэвхи мэдэгдэхүйц суларч, ажилд хөшин хойрго хандахаар барахгүй ажил хаях, монгол хүмүүсийг бүлэглэж зодох, улсын дотоод хэрэгт оролцохыг завдах зэрэг ажиллагаа илэрхий явуулж эхлэв. Үүнийг дагалдан БНМАУ-д байнга сууж байсан хятад цагаачдын зан ааш, ажиллагаа ч мөн хувиран өөрчлөгдөж байсан байна. Суугаа орны хууль дүрэм, зан заншлыг хүндэтгэх ёс гадаад аль ч орны иргэдийн үүрэг байдаг. БНМАУ-д оршин суугаа хятад иргэдийн хувьд гэвэл «хятад ажилчин, ажилтан нар ба тэдний гэр бүлийнхэн Монголд оршин суух хугацаандаа БНМАУ-ын хууль дүрмийг дагаж сахих, монголын ард түмний хэв заншлыг хүндэтгэх үүрэгтэй» гэж хоёр улсын хооронд байгуулсан хэлэлцээрт тусгайлан заасан зүйл байв.<sup>10</sup> Гэтэл хятад ажилчид манай улсын дэвсгэр нутаг дээр 1964 оны дунд үеийг хүртэл 500 шахам удаа өдөөн хатгах үйл ажиллагаа үйлдэж манай улсын гаалийн дүрмийг 361 удаа, олон нийтийн хэв журмыг 40 шахам удаа зөрчсөнөөс гадна ямар ч үндэсгүй шалтаг заан олон удаа ажил хаялт зохион байгуулж байв.<sup>11</sup> Энэ бүхэн бол хөрш зэргэлдээ улс орон, юуны өмнө социалист системийн орнууд, ЗХУ-ын эсрэг хятадын маоист эрх баригчдаас явуулж байсан хагалан бутаргах, их гүрний жанжлах дээрэнгүй бодлоготой шууд холбоотой байсан учир БНМАУ-д оршин амьдарч байсан хятад иргэдийн үйл ажиллагаа нь дээрээс зориуд зохион байгуулсан улс төр, үзэл суртал, эдийн засгийн даралт шахалтын шинжтэй байв. Хятадын маоист эрх баригчдын их гүрний дээрэнгүй бодлого 1966 онд эхэлсэн «соёлын хувьсгал» гэгчийн үед бүр эрээ цээрээ алдсан юм. «Соёлын хувьсгалын» үед манай улсад байсан зарим хятад иргэд БНМАУ-ын эсрэг илэрхий өдөөн хатгасан ажиллагаа үйлдээд бидний ар талд Мао дарга, хятадын олон сая ард түмэн зогсож байна. Монголын ревизионистууд та нар биднийг яаж ч чадахгүй гэх мэтээр айлган сүрдүүлэх гэж оролдож байсан юм.

1967 оны 1 р сарын 31-нд Улаанбаатар хотын төмөр замын буудал дээр Хятадын Элчин сайдын яам хятад иргэдийн цуглааныг зохион байгуулж, Монгол—Зөвлөлтийн найрамдлын эсрэг гүтгэлгийн өдөөн хатгалга үйлдэж байв. Тэрчлэн энэ үед БНМАУ-д суугаа БНХАУ-ын Элчин сайдын яам «Хятад иргэдийн зөвлөл», «Найрамдал эмнэ-

<sup>10</sup> «Үнэн» 1966. VI. 7.

<sup>11</sup> Маоизм маогийнхан. УБ., 1974, 214-р тал.

лэг», «Хятад сургууль» болон манай улсад олон жил амьдарч байсан хятадын зарим харъяат нарыг ашиглан БНМАУ-ын эсрэг өдөөн хатгасан ажиллагааг ил хийж, Маогийн үзэл санааг тулган хүлээлгэх элдэв арга мэх хэрэглэж байв. Хятадын талаас үйлдсэн удаа дараагийн өдөөн хатгалгыг эрс шийдвэртэй эсэргүүцэж 1967 оны 2-р сарын 19-нд БНМАУ-ын ГЯЯ-ны төлөөлөгч мэдэгдэл хийж хэргийн учрыг дэлгэрэнгүй тайлбарласан<sup>12</sup> билээ. Гэвч Хятадын тал БНМАУ-ын эсрэг хийх ажиллагаагаа улам идэвхжүүлсэн юм. Улаанбаатар дахь хятад сургуулийн багш Ван Зыюань, Чэн Лу, Зо Гуйи нар манай улсын нийгмийн хэв журмыг бүдүүлгээр зөрчин, ноцтой өдөөн хатгалга үйлдсэн учир тэднийг арга буюу БНМАУ-ын нутгаас зайлуулж байв. Энэ мэт хэргийг тоочивч барахгүй олноор үйлдэж байсан нь хятадын жирийн хөдөлмөрч ард түмнийг маоист үзэл суртлаар хордуулж, улс төрийнхөө бодлогын золиос болгож байсан тэр үеийн хятадын улс төрийн бодлоготой шууд холбоотой байсан билээ.

Одоо манай улсад хятадын цагаач иргэд 6000 орчим байна. Эдгээр хүмүүсийн ихэнх нь 1945—1965 оны хооронд БНМАУ-д ирж суурьшсан юм. Тэдний дотор Монголд төрсөн мянга гаруй хүн бий. Манайд байгаа хятад иргэдийн цөөн хэсэг нь барилга хөдөө аж ахуй, тээвэр, нийтийн үйлчилгээний газар ажилладаг юм. Манай улсад амьдарч байгаа хятадын цагаач иргэд нь улс ардын аж ахуйн аль нэг салбарт ажиллах, хийсэн ажилдаа тус улсын иргэдийн адил цалин хөлс авах, амрах, хөдөлмөрөө хамгаалуулах, тэтгэвэр тэтгэмж, урамшил шагнал авах, эмчлүүлэх, сурч боловсрох мөн үр хүүхдээ сургууль цэцэрлэг, яслид оруулах зэрэг эрх эдэлдэг юм. Тэднийг хууль тогтоомжоор олгогдсон эрхээ эдлэхийн зэрэгцээ үүргээ хэрэгжүүлэх бодит бололцоогоор манай нам, засаг бүрэн хангаж байдаг билээ. Гэтэл тус улсад хувийн журмаар оршин суудаг БНМАУ-ын харъяат зарим иргэд манай улсын дотор дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, ард түмний уламжлалт хэв заншлыг үл ойшоон, социалист аж төрөх ёсыг бүдүүлгээр зөрчиж, социалист байгуулалтад болон манай иргэдэд эд материал, ёс суртахууны ноцтой хохирол учруулж байсан жишээ их бий. Гэвч манай нам, засгийн газар аливаа асуудлыг дэвэргэх, улс төрийн бодлогодоо ашиглах, түүнийг гуйвуулах явдал хэзээ ч гаргаж байгаагүй бөгөөд ямар ч эгзэгтэй нарийн төвөгтэй асуудлыг ухаалгаар, эв зүйгээр социалист хууль ёс, зарчимд тулгуурлан шийдвэрлэсээр ирснийг хятадын асуудалтай холбогдон гарсан бүх зүйлд хандсан манай үйл ажиллагаа бэлхнээ нотлох билээ.

МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга нөхөр Ю. Цэдэнбал 1978 оны 7-р сард болсон Улаанбаатар хотын намын 19-р бага хурал дээр хятадын цагаач иргэдийн асуудалд манай нам засгаас хандаж байдаг бодлогыг хөндөж хэлэхдээ «Манай орон арьсны өнгө, яс үндсээр ялгаварлахыг хуулиар хориглосон юм. Энэ зарчмыг манай нам, засаг нарийн чанд хэрэгжүүлж байна. Манайд хятадын цөөнгүй иргэд аж төрж байна. БНМАУ-ын хөдөлмөрчид тэднийг хятад гэсэн шалтгаанаар гадуурхдаггүй юм. Хятад иргэд тус орны хөдөлмөрчдийн нэг адил Үндсэн хуулиар батлагдсан эрхийг бүрэн эдэлж байна. Тэд чөлөөтэй хөдөлмөрлөж, амжилт бүтээл гаргасан хүмүүс нь БНМАУ-ын одон, медаль, хөдөлмөрийн баатар цолоор ч шагнуулдаг билээ. Хятад болон гадаадын харъяат бусад иргэдийг ингэж аж төрөх боломжоор хангах явдал манай интернационалч үүрэг мөн. Харин тэднээс БНМАУ-ын

<sup>12</sup> «Үнэн» 1967.ИИ.20.

хууль тогтоомжийг зөрчвөл нийтийн адилаар зэмлэл хүлээлгэх нь мэдээж юм»<sup>13</sup> гэж тодорхойлсон билээ.

Хүний нутагт цагаачлан амьдарч байгаа хятад хүмүүсийг суугаа орны нь эсрэг улс төрийн зорилгоор ашигладаг нь Мао Зэдуны шүтдэг ганц арга байсан бөгөөд хятадын одоогийн удирдагчид ч гэсэн энэ аргыг хэвээр өвлөн авч байгаа юм биш биз гэсэн бодол төрүүлэхүйц байдал сүүлийн үед ажиглагдаж байна. Энэ нь манай улсад амьдран сууж буй зарим хятад иргэдийн үйлдэж буй ажил явдлаас тодорхой болж байна.

1979 онд ах дүү Вьетнамын эсрэг хятадын тал түрэмгийлэл үйлдэхдээ тэнд байсан цагаач иргэдийг улс төрийн бодлогодоо хортойгоор ашигласныг дэлхий дахины хэвлэл өргөн тэмдэглэж байсан билээ. Тэр үед хятадын суртал нэвтрүүлгийн нүсэр аппарат БНСВУ-ыг гүтгэн гүжирдэж, хоёр орны харьцааг зориуд муутгасан бүх буруугаа Вьетнамын талд тохох гэж улайран оролдож байсан юм.

Хятадын засгийн газар сүүлийн үед БНМАУ-д оршин суугаа цагаач иргэдийн асуудалтай холбогдуулан манай бодлогыг гуйвуулан гүтгэсэн мэдэгдлийг дэлхий дахинд тарааж, түүнийгээ бататгахын тулд Хятадад суугаа манай улсын Элчин сайдын яаманд 1983 оны 6-р сарын 3-нд нот өгсөнтэй холбогдуулан манай улсын Гадаад явдлын яам 1983 оны 7-р сарын 6-нд БНМАУ-д суугаа БНХАУ-ын элчин сайдын яаманд хариу нот гардуулсан билээ.

«БНМАУ-д байнга оршин суугаа хятад иргэдийг Улаанбаатараас хөдөө нутагт албадан нүүлгэх буюу тэднийг бөөн бөөнөөр нь БНМАУ-аас хөөн гаргах» үйл ажиллагаа явуулж тэрчлэн «хятад иргэдийг ажлаас халж, БНМАУ-аас гарч явахад нь тэдний эрх чөлөөнд халдаж доромжилсон мэтээр Хятадын ГЯЯ-ны нотод гүтгэснийг манай нот бодит баримтаар няцаасан юм.

Монголын талын зүй ёсны үйлдлийг гуйвуулах, олон нийтийг төөрөгдүүлэх, БНМАУ-д дайсагнасан суртал нэвтрүүлгийн кампани дэгдээх илэрхий зорилгоор хятадын нотод «хэрэг явдал», «байдлыг муутгаж байна» гэх мэт үг хэллэгийг олонтоо хэрэглэсэн нь анхаарал татаж байна гэж манай ГЯЯ-ны нотод өгүүлсэн юм. Ер нь хятад иргэдийн талаар гарсан ялимгүй жижиг ч болов маргааныг хятадын тал элдэв хэлбэрээр өсгөн томруулж, зохиомлоор улс төрийн дүгнэлт хийж, тухайн улсын засгийн газраас хятад иргэдийн эсрэг зориуд зохион байгуулж байгаа үйл ажиллагаа мэтээр нотлохыг урьдал болгодог нь Хятадын эрх баригчдын бодлогонд олонтоо илрэн гарч байсныг тэмдэглэх хэрэгтэй юм.

БНМАУ-д даган мөрдөж буй хууль тогтоомж ёсоор хөдөлмөрийн чадвартай хүн бүр ямар ч улсын харьяат болохыг харгалзахгүйгээр нийгэмд тустай хөдөлмөр эрхлэх үүрэгтэй байдаг билээ. Энэ бол хүнийг үй олноор нь ажилгүйдүүлж, амьдрах аргагүй болгодог хөрөнгөтний болоод бусад нийгмээс үндсээрээ ялгаатай социализмын энэрэнгүй зарчим, хөдөлмөрчин хүнийг халамжлан үздэг манай нийгмийн давуу тал гэдгийг хэн ч үгүйсгэх аргагүй билээ. Манай улсад оршин сууж байгаа хятад цагаач иргэдийн дотор 1983 оны эхний байдлаар хөдөлмөрийн чадвартай 2,5 мянга гаруй хүн байлаа. Гэтэл эдний өчүүхэн хэсэг тухайлбал 300-аад нь байнгын ажил эрхлэж байгаа билээ. Гэтэл Улаанбаатарт буй зарим хятад цагаач иргэдийн амьдрал ихээхэн баян чинээлэг байдаг. Энэ бол тэдний дамын худалдаа эрхэлдэгтэй холбоотой юм. Монголд тодорхой ажил эрхлэхгүй байгаа зарим хятад цагаач иргэдийн хийж байгаа гол зөрчил бол дамын худалдаа

эрхлэх, мөрийтэй тоглоом тоглох зэргээр ямар ч ажил хөдөлмөр хийхгүй хууль бус орлогоор амьдрах явдал байдаг. Ямар нэг шалтгаанаар тогтмол ажил эрхлээгүй иргэдийг хөдөлмөрт татан оролцуулах дэс дараатай арга хэмжээг манай улс хууль тогтоомжийнхоо дагуу авсаар ирсэн, авч ч байна. Хөдөлмөрт татан оролцуулах боломжтой, тус орны янз бүрийн районд ажилгүй байгаа бүх хүмүүсийг үндэс угсаа ялгалгүй ажилд оруулах арга хэмжээ авч байгаа өнөө үед, энэ оны 3-р сараас эхлэн хөдөлмөрийн чадвартай тодорхой тооны хятад иргэдийг БНМАУ-ын Сэлэнгэ, Төв аймгийн зарим сангийн аж ахуйд шилжин очиж ажиллахыг манай засаг захиргааны байгууллагууд зөвлөсөн юм. Энэ нь хөрөнгөтний хэвлэл мэдээллийн хэрэгслүүд Бээжингээс иш татан цуурхаж байгаачлан «цөл газарт» шилжүүлэн нүүлгэх тухай асуудал огт биш юм. Харин ч дурдсан районууд нь байгаль цаг уурын нөхцлөөр их тааламжтай, урьд өмнө хятад цагаач иргэд амьдарч байсан үржил шимтэй газар байсныг нуух хэрэггүй юм. Тэнд очсон хүмүүст болон тэдний гэр бүлийнхэнд мэргэжил чадварынхаа хэрээр ажиллах, тэрчлэн амины туслах аж ахуй эрхлэх бололцоо олгож, суурьшин суух газраа очиход нь үнэ төлбөргүй унаагаар хангаж, мөнгөн тэтгэмж олгож, орон сууц, ахуйн болон хэвийн байдлаар амьдрах бусад бүх нөхцлөөр хангах бололцоог бүрдүүлсэн байсан юм. Гэтэл хөдөө ажиллах томилолт авсан хятад иргэд орон нутгийн засаг захиргааны шийдвэрийг биелүүлэхээс эрс татгалзаж, хөдөлмөрт оролцохоос зайлсхийж БНХАУ руу гарч явахаар шийдсэнээ өөрсдөө мэдэгдсэн билээ. Гадаадын харьяат иргэд эх орондоо буцах нь тэдний хувийн хэрэг учраас түүнд монголын тал ямар ч саад учруулахгүй гэдэг нь тодорхой хэрэг. Гэтэл хятадын тал хэрэг явдлыг санаатайгаар мушгин гуйвуулж, Монголд байгаа хятадын цагаач иргэдийг бөөнөөр нь нутаг буц хэмээн шахан шаардсан мэтээр сурталчилж байгаа нь харамсалтай байна.

БНМАУ-ын Гадаад явдлын яамны нотод «Монголын ард түмэн, манай засаг захиргаа хятадын хөдөлмөрчдөд сайн санаанаас хандаж байдгийг хортойгоор ашиглан, шударга хөдөлмөр эрхлэхийн оронд зүгээр сууж, бусдын хүчийг сорж амьдрахыг урьдал болгодог хорон санаат этгээдүүдийн тухиралтаар хятад иргэдийн олонхи нь Монголоос явж байгаа юм»<sup>14</sup> гэж тэмдэглэсэн билээ. Манай улсад амьдарч байгаа хятадын цагаач иргэдээс хөдөлмөрт байнгын буюу улирлын чанартай гар бие оролцож байгаа хүмүүс бүтэн жилд 7 сая орчим төгрөгийн ажил хийж байгаа атал тэд нийгмийн хэрэглээний фондоос жилд 25 сая төгрөгийн эд материал авч хэрэглэж байгааг үзэхэд бүх зүйл тодорхой болох билээ.

Тус улсын социалист бүтээн байгуулалтанд ч, хятад иргэдийн амьдралын эрх ашигт ч бүрэн нийцэх манай талын энэхүү арга хэмжээг «хятад цагаачдын эсрэг чиглэсэн», «Монгол, хятадын харилцааг сайжруулахад шинэ саад тотгор» болсон хууль бус үйлдэл мэтээр харуулахыг хятадын тал ийнхүү оролдож байгааг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын дотоод хэрэгт шууд оролцож байгаа хэрэг гэж үзэхээс өөр аргагүй юм. Хятадын нотод гаалийн үзлэг хийхдээ цагаач иргэдийн эрх чөлөөнд халдаж, доромжилсон мэтээр зарга үүсгэсэн нь ямар ч ул үндэсгүй бөгөөд харин хятадын галт тэрэгний зарим ажилтан, тэр ч байтугай хятадын дипломатууд монголын гаалийн ажилтнуудын хэвийн үйл ажиллагаанд санаатайгаар саад учруулж, зүй бус үйлдэл хийж байгааг БНХАУ-ын ГЯЯ-д манай тал анхааруулсан нь хоёр орны харилцааг цаа-

<sup>14</sup> «Үнэн» 1983.7.7

шид хэвийн байлгах гэсэн манай бодлого гуйвалтгүй байдгийг харуулсан баримт мөн.

Дашрамд өгүүлэхэд БНМАУ-ын засгийн газар, монголын ард түмэн хятадын хөдөлмөрчдийг хүндэтгэж, тус оронд байгаа хятад иргэдийн амьдрал, ахуй, соёл боловсролын асуудалд багагүй санаа тавьж байдгийг тэмдэглэх хэрэгтэй. Тус улсад хятад хэлээр «Монголын мэдээ» сонин хэвлэгдэж, хятад хэлээр тогтмол радио нэвтрүүлэг явуулдаг бөгөөд мөн хятад сургууль Улаанбаатарт ажиллаж байна. Тэр ч байтугай хятад иргэдийн хүүхдүүдийг монгол сургуульд суралцуулж, улмаар дээд боловсрол эзэмшүүлэх санал гаргасан боловч түүнийг хятадын тал зөвшөөрөн хүлээж аваагүй юм.

Манай нам төрийн ийм энэрэнгүй ардчилсан арга хэмжээг хятадын маоист эрх баригчид ямагт улс төрийн бодлогодоо гуйвуулан ашиглаж, асуудлыг хүндрүүлж байсан тэр үе дахин давтагдахгүй байвал хоёр орны ард түмний уламжлалт харилцаанд ахиц гарах бололцоо одоо үед байгаа юм гэдгийг хэлэх хэрэгтэй. БНМАУ өөрийн хөрш БНХАУ-тай харилцаагаа хэвийн болгохын төлөө ямагт байдаг билээ.

## В ЧЕМ СУТЬ ПРОБЛЕМЫ КИТАЙСКИХ ЭМИГРАНТОВ

### (Р е з ю м е)

По данным некоторых зарубежных источников, в настоящее время вне КНР проживают около 25 млн. китайских граждан. Этот факт всегда находился под пристальным вниманием китайских руководителей, особенно, маоистов, которые использовали китайцев зарубежом как инструмент для проведения великодержавной, экспансионистской политики, вмешательства во внутренние дела других государств.

В Конституциях КНР от 1954, 1975, 1978 и 1982 гг. были зафиксированы положения о китайских гражданах, проживающих зарубежом, что в действительности не было призвано защищать интересы подлинно трудовой части китайских эмигрантов.

Проникновение китайцев в Монголию началось в период маньчжурского господства. Несмотря на определенные запреты и указы маньчжурской администрации, запрещавших массовое переселение, к началу XX века имелось значительное число китайцев в Монголии, особенно в ее южной части. Занимая лучшие пастбища под земледелие, грабя природные богатства, жестоко эксплуатируя трудовой народ посредством торгово-ростовщического капитала, они стремились обосноваться во всех сферах социально-экономической жизни монголов.

После победы Народной революции в Китае и установления дипломатических отношений с МНР, вплоть до 60-х годов китайские граждане, проживающие в МНР вели, в основном, трудовой образ жизни и подчинялись законам МНР.

С 60-х годов, особенно с начала «культурной революции», приехавшие по контракту китайские рабочие и члены их семей постоянно нарушали общественный порядок, совершали провокационные действия в отношении монгольской администрации, бойкотировали рабо-

ту. Эти действия были организованы «сверху» и носили характер политических, идеологических и экономических провокаций и нажима.

В настоящее время в МНР проживают около 6000 китайцев. Им предоставлены те же права и возможности, которыми пользуются и монгольские граждане. Несмотря на это, со стороны китайских граждан до сих пор наблюдаются случаи правонарушений, носящих политическую окраску, что говорит о нежелании нынешнего китайского руководства отказаться от прошлой практики использования китайских эмигрантов в своих корыстных целях.

Политические цели преследовала и шумиха, поднятая недавно вокруг «насильственной высылки» китайцев из МНР.

В ноте МИД МНР от 6-го июля сего года, в частности, говорится: «Достойно сожаления, что китайская сторона, искажая предпринимаемые нашей страной меры по трудоустройству китайских граждан, берет под защиту вызывающие действия нарушителей правопорядка и законности... Попытки же китайской стороны, представить эти меры как незаконную акцию «направленную против китайских эмигрантов», и «новое препятствие на пути улучшения монголо-китайских отношений», можно расценить как прямое вмешательство во внутренние дела Монгольской Народной Республики».